



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 129

Улаанбаатар хот

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр
хэрэгжүүлэх зарим төслийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Улсын Их хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн баримт бичиг”, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 26/09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Нийслэлд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх журам”-ын дагуу хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дор дурдсан төслүүдийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч /Ж.Батбаясгалан/-д үүрэг болгосугай. Үүнд:

1. “Улаанбаатар хог хаягдлын менежментийг сайжруулах” төсөл
2. “Улаанбаатар хүнсний агуулах” төсөл
3. Нийслэлийн хүнсний зарим хэрэгцээг хангах зорилгоор “Улаанбаатар 4 улирлын хүлэмж” төсөл
4. Сайжруулсан түлшний уутыг дотооддоо үйлдвэрлэх “Улаанбаатар нийлэг уут” төсөл
5. Орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, гэр бүлийг гэнэтийн аюул, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хараа хяналтыг сайжруулах төсөл
6. Такси үйлчилгээ цогцоор хөгжүүлэх Шинэ нисэх буудлын зорчигч тээвэрлэх /нийтийн тээврийн үйлчилгээ төсөл
 - а/Тусгай чиглэлийн, шуурхай /экспресс/ үйлчилгээний том оврын зорчигч тээврийн автобус;
 - б/Тусгай чиглэлийн, шуурхай /экспресс/ үйлчилгээний дунд оврын зорчигч тээврийн автобус;
 - в/“Шинэ нисэх буудал орчмын тусгай такси;
7. Нийтийн тээвэрт цахилгаан соронзон галт тэрэг нэвтрүүлэх төсөл

1110100359

2.Дээрх төслүүдийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар зохион байгуулж хэрэгжүүлэхийг “Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” ХК /Ж.Билэгсайхан/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА



Р.ДАГВА